


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар нөлөөлөл хамтын ажиллагаа

Т.Цэндсүрэн Доктор, дэд профессор
МУБИС БСС Нийгмийн ажил арга зүйн тэнхим

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (НҮБ-ын Ерөнхий Ассемблей, 2006)



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших эрхийг хангах, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, сургалтад хамруулах бодлогын шийдвэрийг нийгмийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээ нь хүртээмжтэй байхад нөлөөлөх

Тухай хүний бие эрхтний согог нь өдөр тутмын үйлдэл, үйлийг гүйцэтгэх, өөртөө үйлчлэх, бие даан амьдрах, нийгмийн амьдралд оролцоход нь хэр зэрэг саад болж буйг харгалзан хөгжлийн үр нөлөөг тооцдог.

(ХБИ-ийн ОУ-ын ангилал)

- Дэд бүтэц
- Мэдээлэл
- Харилцаа
- Хандлага

Орчинд нь өөрчлөлт хийх эсвэл туслах хэрэгсэл ашиглах замаар тухайн хүний саад бэрхшээлийг бүрмөсөн арилгах буюу үнэлэгдэхүйц хэмжээгээр багасгах боломж байна.

Бүх хүн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог, хэрэгцээ, тусламж үйлчилгээний талаар мэдлэг, хандлагатай болсноор тэгш үйлчлэх боломжтой болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд суурилсан бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлөх хамтрах

ХБИ-ийн нийгмийн асуудлыг тогтолцооны хүрээнд нь шийдвэрлэх


Нийгмийн капитал, нийгмийн үнэт зүйлсийг бүрдүүлэх

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

- Эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүсийн төлөө
- Эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүстэй хамтран
- Эрх ашиг нь хандагдсан хүмүүс өөрсдөө

Нөлөөлөх, хамтрах үйл ажиллагааны хүрээнд бид юу хийх вэ?

- Бодлого, үзэл баримтлал, хууль тогтоомж хөтөлбөрт өөрчлөлт оруулах үйл ажиллагаа зохион байгуулах
- Үзэл бодлыг өргөн мэдүүлэх, хамгаалах, шийдвэр гаргагч нарт танин мэдүүлэх
- Ойлголт, хандлагыг өөрчлөх, бодлогын шийдвэр гаргах болон санхүүжилтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн оролдлого хийх
- Хүлээн зөвшөөрүүлэхийн тулд тодорхой зорилготой мэдээллийг дамжуулах
- Асуудлыг ил болгох, олон нийтийн анхаарлыг хандуулах, шийдвэрлэх алхам уруу чиглүүлэх



ХБИ-ийн нийгмийн асуудлыг тогтолцооны хүрээнд нь шийдвэрлэх

Сайн сайхан байдалд хариуцлагатай хандах үзлийг харуулсан схем Роберт Чэмберс (Who is Reality, 1997)

ХБИ-ийн нийгмийн асуудлыг тогтолцооны хүрээнд нь шийдвэрлэх

- Хүмүүсийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх
- Асуудал руу олон нийтийн анхаарлыг татах
- ХБИ тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх
- Хамтын ажиллагааны сүлжээ бий болгох, хамтран ажиллах
- Эрхийг хамгаалж, нийгмийн оролцоог дээшлүүлэх, чадваржуулах
- Хөрөнгө нөөцийг төвлөрүүлэх, нэмэгдүүлэх
- Холбогдох албан хаагч, мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, үйл ажиллагааг дээшлүүлэх нөлөөллийн хэлбэрүүдээс ашиглаж болно.

Сайн сайхан байдал

- Амьдралын стандарт
- Нийгмийн халамжинд хамрагдах боломж

Сайхан амьдралын үндэс

- Амьдрах арга
- Амьдралын баталгаа

Сайхан нийгэм

Иргэдийнхээ үндсэн хэрэгцээг хангасан эрүүл аюулгүй орчин нөхцөл бүрдүүлсэн байна.

Нийгмийн капитал,
нийгмийн үнэт
зүйлсийг бүрдүүлэх

*нийгмийн капиталыг
нэмэгдүүлнэ гэдэг нь
хүмүүсийн хоорондын
харилцаа, хамтын
ажиллагаа, бие биенээ
дэмжих сэтгэлийг
бэхжүүлнэ (J.Midgley)*




Олон нийт болон үйлчлүүлэгчид тулгамдаж буй ямар нэгэн асуудлыг өөрчлөхийн төлөө хувь хүн болон хэсэг бүлгийн зан үйлийг өөрчлөхийн тулд:

- Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг ятгах,
- Харилцаа тогтоох
- Олон нийтийг сургах
- Судалгаа шинжилгээний баримт мэдээ цуглуулах
- Мэдүүлэг өгөх, гарын үсэг цуглуулах
- Бүлгийг нэгтгэн зохион байгуулах, жагсаал цуглаан хийх
- Хэвлэл мэдээллийг ашиглах
- Хөрөнгийн эх үүсвэрийг хянах

Иргэдийн оролцоог
нэмэгдүүлэх

Нөлөөллийн дараах хэлбэрүүдийг ашиглаж болно.

- Тохиолдлын нөлөөлөл
- Бүлэг, хамт олны нөлөөлөл
- Улс төрийн, бодлогын нөлөөлөл



Нөлөөллийн ажлын үе шатууд

- Асуудлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх
- Зорилго, зорилтуудыг тодоройлох
- Зорилтот бүлгүүдийг сонгох
- Илгээлт боловсруулах
- Ухуулга сурталчилгааны арга, техник
- Эсвэл сүлжээ байгуулах
- Хөрөнгө сан бүрдүүлэх
- Хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
- Нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх
- Хянах, үнэлэх

Иргэдийн оролцоог
нэмэгдүүлэх

Хэзээ хамгийн
тохиромжтой,
үр дүнтэй

ХБИ онцлог

Хэрэглэх арга
техник

Үйлчилгээний
орчин

Үйлчлүүлэгчийн
нийгмийн
харилцааны
хүрээ

Хамтын ажиллагаа

Нийтлэг зорилгод хүрэх үр дүнтэй үйл ажиллагааг зохицуулахад түншлэл хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй. Түншлэлийг талуудын тэгш эрхтэйгээр оролцох хамтын үйл ажиллагаа гэж тодорхойлж болно.

Түншлэл хамтын ажиллагаа байхын учир

- ✓ Нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө, үзэл бодлоороо хүртэл ялгаатай хүмүүсийг нэгтгэж, хамтран ажиллах бололцоог олгодог.
- ✓ Төрөл бүрийн мэдлэг чадвар, дадлага туршлагатай түншүүд бие биедээ сэтгэл санаа, оюун ухаан, хүч чадлын дэм өгч, хамтын хүчирхэг нөлөөллийн нэгдлийг бий болгодог.
- ✓ Салбаруудыг хооронд нь ойртуулж, салбарын дотоод болон, салбар хоорондын харилцааг зохицуулж, нэгтгэн зангиддаг.
- ✓ Мэдлэг, мэдээллийн эрчимтэй солилцоо явагддаг.
- ✓ Түншлэлийн үр дүнд тогтвортой, нээлттэй, тэгш эрхтэй харилцаа тогтдог.
- ✓ Түншлэлийн харилцаа нь бусдад үлгэр дууриал болж, нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлдэг.

Хамтын ажиллагааг бий болгохдоо:

- Зорилтыг бусдад ойлгомжтой болгох
- Хамтран ажиллаж байгаа байгууллагууд, өөрсдийн ажлын хүрээ болон дотоод нөөц бололцоо байдаг гэж ойлгож, хүндэтгэсэн байх
- Чухал гэж үзэх шийдвэрүүдийг хамтран гаргах
- Хамтран ажиллах гэсэн хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийг оролцуулах
- Хамтын ажиллагааны үүрэг хариуцлагыг тодорхойлж, үүрэг даалгаврыг тэнцүү хуваарилах
- Тогтмол хуралдаж, байнга мэдээллээ солилцож байх
- Уулзалт хурал хийж, олсон амжилтын талаар мэдээлэл түгээх

Хамтын ажиллагааг хөгжүүлэх үе шатууд

Хамтын ажиллагааны
талаар

Нэгдмэл
ойлголттой
болох

Үндэсний
хэмжээнд

Орон
нутгийн
хэмжээнд

Хөндлөнгийн
байгууллагын
үүрэг

Хамтран
ажиллах
сүлжээ үүсгэх



**Нийгмийн сайн
сайхан байдал**

**Нийгмийн үйлчилгээг
чанартай хүргэх**

**Бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэнд олон
нийтийн оролцоог хангах нь**

Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн
учир.,

Иргэд, олон нийтийг хамтран ажиллаж, эдийн засаг
нийгмийн хувьд бусдаас хараат байдлаас гарахад нь
туслаж, улмаар бие даалган чадавхижуулах явдал
байдаг

Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн учир.,

- Асуудал. Олон нийтийн /орон нутгийн/ асуудлууд нь хамтын шинжтэй байдаг бөгөөд ганц нэгээрээ, эсвэл гадны ямар нэгэн байгууллагаас хариуцан шийдэх боломжгүй байна.
- Нөөц, боломж. Орон нутаг ба олон нийтэд өөртөө тулгарсан асуудлаа гадны зээл тусламжид дулдуйдахгүйгээр өөрсдөө шийдэх нөөц, бололцоо байдаг. Олон нийт саад бэрхшээлийг өөрсдийн хүчээр шийдэх боломжтой байдаг.
- Өөрийгөө мэдэх. Орон нутгийнхан бие даан шийдвэр гаргах ба гаргасан шийдвэр нь орон нутгийнхаа онцлог, соёл, уламжлал, зан заншил, байгаль орчин, шашин шүтлэгийг хүндэтгэсэн, мэдэрсэн байх болно. Гадны хүмүүсийн хийсэн сонголт нь тэр бүр орон нутгийн олон нийтийн хүсэл зорилгод нийцсэн байдаггүй.

Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн учир.,

- Ардчилсан байх. Төлөвлөх, шийдвэр гаргах үйл явц нь доороос дээш чиглэсэн байна. Иргэний нийгмийн болон жам ёсны хөгжил бий болно.
- Нийтлэг эрх ашиг. Орон нутгаас сонгогдсон төслүүд нь хувь хүн, бүлгийн бус нийтийн ашиг сонирхолд нийцсэн байх болно.
- Хамтын ухамсар. Олон нийтийн оролцоо нь “минийх”, “биднийх” гэсэн ухамсар төрүүлж, тэр нь хөгжлийн үр дүнд хүрэх хөшүүрэг болно.

Дасгал: Нөлөөллийн чадавхи бий болгох загвар /spider/


Бүлгийн нөлөөллийн чадавхид
хийх өөрийн үнэлгээ

0 – Чадваржихийн тулд маш их
ажиллах шаардлагатай


1 – Чадваржихийн тулд ихээхэн
ажиллах шаардлагатай

2 – Цаашид зарим талаар
чадваржих боломжтой сайн
нөхцөл байдал

3 – Бага хэмжээгээр чадваржих
боломж бүхий төгс нөхцөл
байдал



Нийгмийн хөгжлийн үйл явцын загвар



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар нөлөөлөл
хамтын ажиллагааг хөгжүүлэхийн учир,

*Аюулгүй орчин бий болгоно
гэдэг нь ямар нэг нийгмийн
орчинд аюулгүй байдлыг бий
болгож хадгалахын тулд
хийж байгаа хамтын
чармайлт юм.*


*Тогтолцооны өөрчлөлт хийхэд зориулсан
Аюулгүй орчны загвар Sandra L. Bloom
M.D. Community Works*

Хүний зан үйлийн ихэнх эмгэг нь
дорой нэгнээ дээрэлхэх явдал, биеийн
болон сэтгэл санааны чадвараа алдах,
төрөл саднаасаа хагацах зэргээс болж
зовж шаналахаас үүдэлтэй бөгөөд
үйлчлүүлэгчид , ажилтан хэн ч байлаа
гэсэн тэдний зан авир тухайн
асуудалтай холбоотой идэвхитэй
нөлөөлж байгаа хүчин зүйлтэй нь
холбон ойлгох ёстой юм.

Цочрол гэмтлийн хувь хүн болон тогтолцоонд нөлөөлөх үр дагаврыг бууруулах соёл (Haigh, 1999)

Системийн хүчирхийлэл гэдэг нь хувь хүн азгүй нэгнийгээ зориуд хорлох үйлдэл биш, энэ нь өвчтөнүүдийн эрх ашгийн төлөө сайн зүйл хийж байна гэж итгээд эрх мэдэл бүхий хүмүүсийн хийсэн үйл ажиллагаанаас болж гарсан үр дагавар

- Ээнэгшил – төрөл садны соёл
- Хязгаарлалт – аюулгүй байдалтай холбоотой соёл
- Харилцаа – нээлттэй, ил тод байх соёл
- Оролцоо – оролцоо иргэний соёл
- Байгууллага – чадваржих соёл



Эх сурвалж

1. Нийгмийн хөгжлийн төв., Нийгмийн ажлын мэдээлэл, сургалт, судалгааны төв. (2006). Нөлөөллийн ажлын арга зүй цуврал 1, 2, 3, 4. Улаанбаатар.
2. Richard Hoefler. (2006). *Advocacy Practice for Social Justice*. Chicago: Illinois.
3. Nancy Amidei. *So we want to make a Difference: Advocacy is the Key*.
4. The policy project. *Advocacy training manual*.